



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН
ТООЦОО**

**СУДАЛГААНЫ
ТАЙЛАН**

2023

Улаанбаатар хот

Судалгааны зөвлөх:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur)

Судалгааг хянасан:

Г.Давааням

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LLD.)

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Түмэндэмбэрэл

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Хууль зүйн ухааны доктор (Ph.D.)

Р.Хатансайхан

Эрдэм шинжилгээний ажилтан

О.Энххүслэн

Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО.....	5
Нэг. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох	5
Хоёр. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.....	8
Гурав. Гарах зардлыг урьдчилан тооцох	10
Дөрөв. Үр дүнг тооцох	11
Тав. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	11
ИРГЭНД УЧРАХ ЗАРДЛЫН ТООЦОО.....	13
Нэг. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох.....	13
Хоёр. Зардал тооцох	16
Гурав. Тоон үзүүлэлтийг тооцох.....	19
Дөрөв. Зардлын дүнг тооцож гаргах.....	21
Тав. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах	23
ДҮГНЭЛТ, САНАЛ.....	24

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

/ ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ/

УДИРТГАЛ

Энэхүү зардлын тайлангийн зорилго нь Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд иргэн, төрийн байгууллагын үйл ажиллагаанд холбогдуулан энэхүү төсөлд тусгасан үүргийг гүйцэтгэхэд зайлшгүй гаргах зардлыг тооцож, тэдгээрт ногдох зардал, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, зохицуулалтын боломжит хувилбарыг боловсруулахад оршино.

Тус хуулийн төсөл нь бэлчээрийн газрыг ашиглах, сайжруулах, хамгаалахтай холбоотой харилцааг Газрын тухай хуульд нэмэлтээр оруулж, дараах зохицуулалтыг тусгасан байна. Үүнд:

1. Нэр томъёоны тодорхойлолт хэсэгт шинээр тусгагдсан нэр томъёонууд болох “бэлчээр ашиглагчдын бүлэг”, “отрын нөөц бэлчээр”, “бэлчээрийн даац” гэх мэт нэр томъёонуудын тайлбарыг тусгасан;
2. Газрын тухай хуульд одоо байгаа хөдөө аж ахуйн газар гэх зохицуулалтыг шинэчлэн улирлын бэлчээр болон бусад бэлчээрийг хамруулахаар тодорхойлж энэхүү бэлчээрийг бэлчээр ашиглагчдад гэрээгээр ашиглуулахаар зохицуулсан. Ийнхүү ашиглуулахдаа зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх талаар Засгийн газар журмыг батлан, төрийн захиргааны төв байгууллага улс, аймаг, сум, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний аргачлалыг баталж түүний дагуу төлөвлөгөөг гарган бэлчээр ашиглагчтай тухайн шатны Засаг дарга гэрээ байгуулан бэлчээрийн газрыг ашиглуулахаар байна;
3. Бэлчээр ашиглагч буюу бэлчээр ашиглагчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, малчин иргэний бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалахтай холбоотой эрх, үүргийг тодорхойлж, тэдний байгуулах гэрээний талаар тусгаснаас гадна хориглох үйл ажиллагаа болон хохирлыг нөхөн төлөх харилцааг мөн зохицуулсан байна.

Дээрх нэмэлт, өөрчлөлтэй холбоотойгоор хэрэгжилтийн явцад гарах зардлыг холбогдох тооцооллын дагуу гүйцэтгэсэн болно. Ингэхдээ зардлын тооцоог Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн 18.1 дэх хэсэгт тусгаснаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-д дурдсаны дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, эрх зүйн зохицуулалтад хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардал тус бүрээр тооцон боловсрууллаа.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын зардлыг нэмэлт өөрчлөлт орсон зүйл заалт тус бүрээр тооцон боловсруулсан. Өөрөөр хэлбэл, одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжид хэвээр үлдсэн зохицуулалтууд нь иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад нэмэлтээр зардлын нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзэв.

Энэхүү зардлын тооцооны тайлан нь дараах үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд¹:

1. Төрийн байгууллагын зардлын тооцоо
2. Иргэнд учрах зардлын тооцоо

¹ Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд хуулийн этгээдийн гүйцэтгэх чиг үүрэг, стандарт үйл ажиллагааг тусгаагүй учир хуулийн этгээдийн зардлын тооцоог гаргах боломжгүй.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
3. Гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Нэг. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлоход дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллагууд, тэдгээрийн гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан төрийн захиргааны үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг дараах байгууллагууд гүйцэтгэхээр байна.

1. Засгийн газар
2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
3. Сумын газрын даамал, дүүргийн газрын алба
4. Аймаг, сум иргэдийн төлөөлөгчдийн хурал
5. Аймаг, сум, багийн засаг дарга

/Хүснэгт 1/

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэх холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт	Чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага
“Бэлчээрийн газрыг бусдад гэрээгээр ашиглуулах, зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах, нөхөх сэргээх журам батлах”	18.1.8.энэ хуулийн 6.5-д заасан бэлчээрийн газрыг бусдад гэрээгээр ашиглуулах, зохистой ашиглах, хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх журмыг батлах.”	Засгийн газар

<p>“Улс, аймаг, сум, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний аргачлалыг батлах”</p>	<p>19.1.12.Улс, аймаг, сум, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний аргачлалыг батлах.</p>	<p>Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</p>
<p>“Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хэмжээ, байршил, хил заагийн зургийг үйлдэх, газрын мэдээллийн санд бүртгэл”</p>	<p>23.4.7.энэ хуулийн 11.2-т заасан гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээ, байршил, хил заагийн зургийг үйлдэх, газрын мэдээллийн санд бүртгэх;</p>	<p>Сумын газрын даамал, дүүргийн газрын алба</p>
<p>“Отрын нөөц бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг тогтоох”</p>	<p>52.7.1.аймаг дундын отрын нөөц бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил заагийг холбогдох аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар</p>	<p>Засгийн газар</p>
<p>“Отрын нөөц бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг тогтоох”</p>	<p>52.7.2.сум дундын отрын нөөц бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг холбогдох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал;</p>	<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал</p>
<p>“Отрын нөөц бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг тогтоох”</p>	<p>52.7.3.сумын отрын нөөц бэлчээрийн газрын хил заагийг холбогдох багийн иргэдийн Нийтийн Хурал, сумын Засаг даргын санал, сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал.</p>	<p>Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал</p>
<p>“Бэлчээрийг гэрээгээр ашиглуулах шийдвэр гаргах”</p>	<p>52.8.Энэ хуулийн 52.3, 52.4-т заасан бэлчээрийг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг бэлчээр ашиглагчдын бүлгийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн хүсэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга гаргана.</p>	<p>Тухайн шатны Засаг дарга</p>
<p>“Отрын нөөц бэлчээрийн гэрээгээр ашиглуулах, мал оруулах, малаас чөлөөлөх асуудлыг бэлчээрийн газрын төлөв байдал, чанар, даацад тохируулан шийдвэрлэх”</p>	<p>52.13.1.аймаг дундын отрын нөөц бэлчээрт холбогдох аймгийн Засаг даргын саналыг үндэслэн хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;</p>	<p>Засгийн газрын гишүүн.</p>

<p>“Отрын нөөц бэлчээрийн гэрээгээр ашиглуулах, мал оруулах, малаас чөлөөлөх асуудлыг бэлчээрийн газрын төлөв байдал, чанар, даацад тохируулан шийдвэрлэх”</p>	<p>52.13.2.сум дундын отрын нөөц бэлчээрт холбогдох сумын Засаг даргын саналыг үндэслэн аймгийн Засаг дарга;</p>	<p>Аймгийн Засаг дарга</p>
<p>“Отрын нөөц бэлчээрийн гэрээгээр ашиглуулах, мал оруулах, малаас чөлөөлөх асуудлыг бэлчээрийн газрын төлөв байдал, чанар, даацад тохируулан шийдвэрлэх”</p>	<p>52.13.3.сумын отрын нөөц бэлчээрт холбогдох багийн Засаг даргын саналыг үндэслэн сумын Засаг дарга.</p>	<p>Сумын Засаг дарга</p>
<p>“Улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил заагийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн байршилтай уялдуулах”</p>	<p>52.15.Улсын чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн газрын байршил, хэмжээ, хил заагийг мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгийн байршилтай уялдуулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн Засгийн газар тогтооно.</p>	<p>Засгийн газар</p>
<p>“Орон нутгийн чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг мал тууврын замын чиглэлтэй уялдуулах”</p>	<p>52.16.Орон нутгийн чанартай дамжин өнгөрөх бэлчээрийн газрын хэмжээ, хил заагийг мал тууврын замын чиглэлтэй уялдуулж, харьяалах сум, дүүргийн Засаг даргын санал, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга тогтооно.</p>	<p>Аймгийн, нийслэлийн Засаг дарга</p>
<p>“Сум багийн засаг дарга бэлчээрийн газрыг хамгаалах талаар авах арга хэмжээ”</p>	<p>52.19.1.сумын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд тусгасан бэлчээрийг улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, отор нүүдэл хийх сар, улирлын хуваарийг мөрдүүлэх;</p> <p>52.19.2.газрыг цөлжилтөөс сэргийлэх, бэлчээрт мод, бут сөөг, олон наст ургамал тарих, бууцаар бордох, хаших зэрэг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах ажлыг зохион байгуулах;</p> <p>52.19.3.бэлчээр, хадлангийн газар болон байгалийн нөөцийн хамтын менежментийг хэрэгжүүлэх, биологийн төрөл, зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор зам, даваа засах, гүүр, инженерийн хийцтэй</p>	<p>Сум, багийн Засаг дарга</p>

	худаг, хөв цөөрөм барьж байгуулах, булаг шандны эхийг хамгаалах зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх.	
--	---	--

Төрийн байгууллагын зардлыг тооцохын тулд Газрын тухай хуулийн төсөл дэх төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, ажил үйлчилгээнд хамааралтай бүх байгууллага бус, гол чиг үүрэг бүхий байгууллагыг сонгох нь зүйтэй. Энэ нь хуулийн төслийн хүрээнд авч үзвэл Сумын газрын даамал байна. Ажил үйлчилгээг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг нь тодорхойлно. Стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо хэт нарийвчлахгүйгээр ерөнхий байдлаар бүлэглэх зарчмыг баримтлав. Тохиолдлын тоог нь тогтоох боломжгүй үйл ажиллагаа буюу хуулийн хэрэгжилтэд хяналт тавих түүнчлэн төрийн захиргааны төв байгууллагын бодлого боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцохгүй.

/Хүснэгт 2 /

Төрийн байгууллагын гүйцэтгэх ажил болон стандарт үйл ажиллагаа

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа
Сумын газрын даамал	“Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг газрын зургийг мэдээллийн санд бүртгэх”	Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээг тогтоох
		Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн байршил тогтоох
		Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хилийн заагийн зургийг үйлдэх
		Мэдээллийн санд бүртгэх

Хоёр. Ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх давтамж** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо сумын газрын даамалтай холбогдох мэргэжилтнүүдээс ярилцлага авч, тэдгээрийн гүйцэтгэсэн ажил үйлчилгээгээр баримжаалж тогтоосон болно. Гэсэн хэдий ч зарцуулах хугацааны хувьд сумын газрын нутгийн хэмжээнээс хамааран ялгаа гарахаар байна. Жишээлбэл, Төв аймгийн Архуст сумын хувьд 829 км² газартай. Тус сумын газрын даамалтай ярилцах үед уг “...газрыг мэдээллийн санд бүртгүүлэхэд 1 хоног хугацаа зарцуулах боломжтой хэмээв...” Өөрөөр

хэлбэл манай улсын нэг сум дунджаар 3.500-4.500 км² нутагт дэвсгэртэй² гэж тооцвол дунджаар 4.8 хоног зарцуулахаар байна. Иймд дундаж хугацааг 4.8 хонгоор тооцлоо.

Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд тусгасан төрийн байгууллагын гүйцэтгэх үүргийг зөвхөн сумын газрын даамлын гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн стандарт үйл ажиллагаа дээрх хэсэгт тогтоосон билээ. Уголлох чиг үүргийг гүйцэтгэж буй байгууллагын тоо, давтамж өөр байх тул хүрээ бүрт ялгамжтай байдлаар тохиолдлын тоог тооцоолов. Тухайлбал:

- Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээг тогтоох, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн байршил тогтоох, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хилийн заагийн зургийг үйлдэх ажлыг бэлчээр ашиглагчдын бүлэг хариуцан хийх боломжтой. Иймд гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээг тогтоох, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн байршил тогтоох, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хилийн заагийн зургийг үйлдэх ажлыг зардлын тооцооноос хасаж тооцов.
- Харин гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээ, байршил, хил заагийн зургийг үйлдсэний дараа мэдээллийн санд бүртгэх ажлыг газрын даамал хийнэ. Манай Улсын хувьд 330 сум байдаг тул тохиолдлын тоог 330 гэж үзлээ.³

/Хүснэгт 3/

Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээ	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Сумын газрын даамал	Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг зургийг бүртгэх”	Бэлчээрийн гэрээг мэдээллийн санд бүртгэх	2.304	330	760.320
Нийт					760320

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

² Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ, 37 дахь тал

³ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ, 28 дахь тал.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу нэмэгдэх орон тоо гарна.

/Хүснэгт 4/

Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Төрийн байгууллага	760.320	96.000	7.92

Гурав. Гаргах зардлыг урьдчилан тооцох

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал⁴-г тооцно.

Аюулгүй байдал, хамгаалалтын тасгийн нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Сумын газрын даамал нь (ТЗ-5) жилийн дундаж цалинг 9.498.384 төгрөгөөр нэг албан хаагчийн цалингийн зардлыг тооцлоо.⁵

Нэг албан хаагчийн нэг жилийн цалингийн зардал нь **9.498.384** төгрөг байна. Түүнд ногдох НДШ нь **1.234.789** төгрөг. Иймд, нэг ажилтанд ногдох нийт цалингийн зардал нь **10.733.174** төгрөг байна.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

/Хүснэгт 5/

Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Төрийн байгууллага	7,92	10.733.174	85,006,738

⁴ Хүний нөөцийн зардал гэдэгт тухайн үүргийг гүйцэтгэх төрийн албан хаагчийн авч болох бүх нэмэгдэл, тусламж, төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн дунджаар гаргасан зардал хамаарна.

⁵ [main1580721320.pdf\(dundgovi.gov.mn\)](http://main1580721320.pdf(dundgovi.gov.mn))

Дөрөв. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал илэрхийлэгдэнэ.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардлууд орно.

Газрын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн хүрээнд сумын газрын даамлын гэрээгээр ашиглуулах бэлчээрийн газрын хэмжээ, байршил, хил заагийн зургийг үйлдэх, газрын мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааны хүрээнд нэмэлт болон бусад зардал гарахгүй.

Нийт зардлыг тооцох

/Хүснэгт 6/

Нэг албан хаагчид ногдох зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Бусад зардал
Нийт Зардлын хэмжээ	85,006,738	-	-
Нийт зардал			85,006,738

Эндээс хүний нөөцийн зардал буюу **85,006,738** нь төрөөс шууд гарахгүй боловч төрийн байгууллагын ажилтнуудын нийт хугацаанд ногдох дүн гэдгийг анхаарах нь зүйтэй.

Тав. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хувилбарыг нягтлах шатанд хуулийн төсөлд шинээр нэмэгдэж байгаа буюу өөрчлөгдөж буй зохицуулалттай холбоотой төрд үүсэх зардлыг хэрхэн багасгах, эдийн засагт дарамт багатай өөр хувилбар боломж байгаа эсэхийг нягталж үзнэ.

Хувилбарыг нягтлах ажлыг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу гүйцэтгэнэ:

1. Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх;
2. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;
3. Шинээр үүсгэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;
 - Стандарт үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэх боломжтой эсэх
Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд сумын газрын даамлын бэлчээрийн гэрээг мэдээллийн санд бүртгэх чиг үүргийг цахимаар гүйцэтгэх боломжгүй.
 - Тохиолдлыг тоог багасгах боломж байгаа эсэх
Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу сумын газрын даамал нь тухайн нутаг дэвсгэр байгуулсан бэлчээрийн гэрээг бүртгэх чиг үүрэгтэй. Энэ ч утгаараа уг газрын даамлын бэлчээрийн гэрээг бүртгэх тохиолдлын тоог

багасгах боломжгүй. Харин улсын хэмжээнд бэлчээрийг гэрээг бүртгэсний дараа газрын даамалд ирэх ажлын ачаалал багасах боломжтой. Өөрөөр хэлбэл манай улсын хэмжээнд бэлчээрийг гэрээг өмнө нь нэгдсэн байдлаар бүртгэж байгаагүй. Ийнхүү бэлчээрийн гэрээний нэгдсэн бүртгэлийг 330 сумын хүрээнд үүсгэх тул тохиолдлын тоог багасгах боломжгүй.

- Шинээр үүсгэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх

Газрын тухай хуульд сумын даамалд бэлчээрийн гэрээг бүртгэх үүрэг байгаагүй. Өөрөөр хэлбэл, өмнө нь сумын даамал нь бэлчээрийн гэрээг бүртгэж байгаагүй. Мөн газрын даамлын өмнө гүйцэтгэж байсан чиг үүрэгтэй үүнтэй төстэй буюу бэлчээрийн гэрээг бүртгэх үүргийг нэгтгэх үүрэг байгаагүй. Иймд газрын даамалд шинээр үүсгэж буй бэлчээрийн гэрээг бүртгэх үүргийг газрын даамлын өмнө нь хүлээж байсан үүрэгтэй нэгтгэх боломжгүй.

ИРГЭНД УЧРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Хуулийн төсөлд тусгагдсан бэлчээр ашиглагч буюу малчин өрх, мал, амьтан бүхий этгээд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэнд үүсэх зардлыг тухайн хэсэгт тооцоолно.

Иргэнд үүсэх зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийнэ. Үүнд:

1. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох
2. Зардал тооцох
3. Тоон үзүүлэлтийг тооцох
4. Зардлын дүнг тооцож гаргах
5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Нэг. Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Тус хуулийн төсөлд одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн зүйл заалтад өөрчлөлт орсон болон нэмж туссан, бэлчээр ашиглагч иргэний зардалд нөлөөлөх зүйл заалтыг дараах хүснэгтээр харуулав.

/Хүснэгт 7/

Хуулийн төсөлд тусгагдсан иргэний зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн зохицуулалтын агуулга	Хуулийн төслийн зохицуулалт
Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахтай холбоотой ерөнхий зохицуулалт	6.5.Улирлын бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн сайжруулах зориулалтаар энэ хуулийн 11.2-т заасан бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглуулна. 11.2.Улирлын бэлчээрт өвөл, хавар, зун, намрын улиралд ашиглах бэлчээрийн газар хамаарна.
Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахтай холбоотой тусгай зохицуулалтууд	52.3.Энэ хуулийн 11.2-т заасан бэлчээрийг энэ хуулийн 3.1.15-д заасан бүлэгт гэрээгээр ашиглуулна. 52.4.Энэ хуулийн 11.2-т заасан зун болон намрын улирлын бэлчээрийг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид гэрээгээр ашиглуулна. 52.8.Энэ хуулийн 52.3, 52.4-т заасан бэлчээрийг гэрээгээр ашиглуулах шийдвэрийг бэлчээр ашиглагчдын бүлгийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн хүсэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга гаргана. 52.9.Энэ хуулийн 52.3, 52.4-т заасан гэрээнд дараах зүйлийг тусгана: 52.8.1.бэлчээр ашиглуулах талаарх Засаг даргын шийдвэр; 52.8.2.бэлчээр ашиглагчдын бүлэг болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч этгээдийн оноосон нэр; 52.8.3.хэмжээ, байршил, хил зааг; 52.8.4.гэрээний хугацаа; 52.8.5.талуудын эрх үүрэг, хариуцлага; 52.8.6.бэлчээрийн даац, бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгаа; 52.8.7.хамгаалах, сайжруулах, нөхөн сэргээх төлөвлөлт;

	<p>52.8.8.энэ хуулийн 52.3, 52.4-т заасан гэрээнд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлыг улмаас бусдын малыг гэрээт бэлчээрт оруулах;</p> <p>52.8.9.хуульд заасан бусад.</p> <p>52.10.Энэ хуулийн 52.8-д заасан шийдвэр нь бэлчээрийн газрын хил зааг, хэмжээ, байршлын талаар хүсэлт гаргасан бэлчээр ашиглагчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч талуудын эрх тэгш байдлыг хангасан байна.</p> <p>52.11.Шинээр өрх тусгаарлаж байгаа болон шилжиж ирсэн малчин өрхийг бэлчээрийн даацад нийцүүлэн гэрээгээр ашиглуулах бэлчээрт оруулж болно.</p> <p>52.12.Энэ хуулийн 52.3-т заасан газрыг гэрээгээр ашиглуулах хугацаа 15 жилийн хугацаатай байх бөгөөд бэлчээр ашиглалтын гэрээний биелэлтэд үндэслэн анх гэрээ байгуулсан хугацаагаар сунгаж болно.</p> <p>52.5.Монгол Улсын нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувь нь отрын нөөц бэлчээр байна.</p> <p>52.6.Отрын нөөц бэлчээрт дараах бэлчээр хамаарна:</p> <p>52.6.1.аймаг дундын;</p> <p>52.6.2.сум дундын;</p> <p>52.6.3.сумын.</p> <p>52.14.Отрын нөөц бэлчээрийн газрыг зургаан сар хүртэлх хугацаатайгаар малчин иргэнд гэрээгээр ашиглуулна.</p>
Бэлчээрийг ашиглах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон гарах зардал	53.2.1.энэ хуулийн 52.3-т заасан гэрээний үүргээ биелүүлэх;

/Хүснэгт 8/

Иргэний гүйцэтгэх ажил болон стандарт үйл ажиллагаа

Чиг үүргийг гүйцэтгэгч	Хуулийн төслийн дэх холбогдох чиг үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Бэлчээр ашиглагчдын бүлэг	Улирлын бэлчээрийг (өвөл, хавар, зун, намрын улиралд ашиглах бэлчээр) гэрээгээр ашиглах	<p>-Бүлэг байгуулахаар санаачлан хоорондоо зөвшилцөх</p> <p>-Зөвшилцөлд хүрсэн малчин өрхүүд бүлэг үүсгэн байгуулах хурал хийж, үүсгэн байгуулсан баримт бичгээ баталгаажуулах</p> <p>-Бүлгийн ахлагчаа сонгож хамтран ажиллах гэрээ, дүрмээ батлах</p> <p>-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах</p> <p>-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх</p> <p>-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах</p>

		<p>-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах</p> <p>-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах болон малчдын бүлэг байгуулах хүсэлт гаргах /Малчдын бүлгийн ахлагч, бусад малчин өрх, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл, оршин суугаа хаяг иргэний үнэмлэхийн хуулбар / малчин өрх бүрийн нэр дээр тоологдсон малын төрөл, тоог заасан жагсаалт; газрын зураг/</p> <p>-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх</p> <p>-Гэрээ байгуулах</p> <p>-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх</p> <p>-Гэрээ сунгуулах хүсэлт</p>
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч	Зун, намрын бэлчээрийг гэрээгээр ашиглах	<p>-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах</p> <p>-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх</p> <p>-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах</p> <p>-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах</p> <p>-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах</p> <p>-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх</p> <p>-Гэрээ байгуулах</p> <p>-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх</p> <p>-Гэрээ сунгуулах хүсэлт</p>
Малчин иргэн	Отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглах	<p>-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах</p> <p>-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх</p> <p>-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах</p> <p>-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах</p> <p>-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах</p>

		<p>-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх</p> <p>-Гэрээ байгуулах</p> <p>-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх</p>
--	--	--

Хоёр. Зардал тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр иргэнд үүсэх зардлын хэмжээг мөнгөн дүнгээр урьдчилан тооцож гаргана.

Дээрх үйл ажиллагаанд зарцуулах цаг хугацаа тухайн үүргийг хэрэгжүүлэхэд гарах мөнгөн зардлыг тус тус тооцно.

Тухайн үүргийн дагуу хичээн төрлийн үйл ажиллагаа хийх ёстойг тодорхойлж агуулгаар нь нэтгэж үүрэг бүрийг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг тогтоох нь харилцан адилгүй боловч тухайн хуулийн үйлчлэлд хамаарах иргэдийн хувьд амьдарч буй газар нутаг, нийгмийн байдал зэргээс хамааран цаг хугацааг баримжаалан тооцно.

Бэлчээр ашиглагч буюу бэлчээр ашиглагчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, малчин иргэн тус бүрийн бэлчээр ашиглах гэрээ байгуулах үйл ажиллагаа, түүнд зарцуулах хугацааг дараах байдлаар тогтоов.

/Хүснэгт 9/

Иргэний гүйцэтгэх стандарт үйлчилгээ буюу үйл ажиллагаанд зарцуулах хугацаа

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	
Бэлчээр ашиглагчдын бүлэг улирлын бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Бүлэг байгуулахаар санаачлан хоорондоо зөвшилцөх	2 хоног	Нийт: 24 хоног 1 цаг 10 минут = 197 цаг 10 минут (11830 минут)
	-Зөвшилцөлд хүрсэн малчин өрхүүд бүлэг үүсгэн байгуулах хурал хийж, үүсгэн байгуулсан баримт бичгээ баталгаажуулах	1 хоног	
	-Бүлгийн ахлагчаа сонгож хамтран ажиллах гэрээ, дүрмээ батлах	1 хоног	
	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах	1 хоног	
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх	1 хоног	
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах	1 хоног	
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах	1 хоног	
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах болон малчдын бүлэг байгуулах хүсэлт гаргах /Малчдын бүлгийн ахлагч, бусад	14 хоног	

	малчин өрх, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл, оршин суугаа хаяг иргэний үнэмлэхийн хуулбар / малчин өрх бүрийн нэр дээр тоологдсон малын төрөл, тоог заасан жагсаалт; газрын зураг/		
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх	1 хоног	
	-Гэрээ байгуулах	1 цаг	
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх	1 хоног	
	-Гэрээ сунгуулах хүсэлт	10 минут	
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч зун, намрын бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах	1 хоног	Нийт: 20 хоног 1 цаг 10 минут = 161 цаг 10 минут (9670 минут)
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх	1 хоног	
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах	1 хоног	
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах	1 хоног	
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах	14 хоног	
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх	1 хоног	
	-Гэрээ байгуулах	1 цаг	
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх	1 хоног	
	-Гэрээ сунгуулах хүсэлт	10 минут	
Малчин иргэн отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах	1 хоног	Нийт: 20 хоног 1 цаг = 161 цаг (9660 минут)
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх	1 хоног	
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах	1 хоног	
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах	1 хоног	
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах	14 хоног	
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх	1 хоног	
	-Гэрээ байгуулах	1 цаг	
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх	1 хоног	

Тайлбар: Хоногийн ажлын цагийг 8 цагаар тооцов.

Мөнгөн зардлыг тооцохдоо тухайн үүргийг хэрэгжүүлэхэд иргэнээс зайлшгүй гарах мөнгөн зардал буюу бодит, тогтсон зардлыг тооцно. Үүргийг хэрэгжүүлэхэд тухайн иргэнээс гарч болох замын зардлыг тооцохгүй⁶.

/Хүснэгт 10/

Иргэний гүйцэтгэх стандарт үйлчилгээ буюу үйл ажиллагаанд зарцуулах мөнгөн зардал

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Мөнгөн зардал /төгрөг/	
Бэлчээр ашиглагчдын бүлэг улирлын бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Бүлэг байгуулахаар санаачлан хоорондоо зөвшилцөх	25.860 ⁷	Нийт: 142.323
	-Зөвшилцөлд хүрсэн малчин өрхүүд бүлэг үүсгэн байгуулах хурал хийж, үүсгэн байгуулсан баримт бичгээ баталгаажуулах		
	-Бүлгийн ахлагчаа сонгож хамтран ажиллах гэрээ, дүрмээ батлах		
	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах		
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх		
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах		
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах болон малчдын бүлэг байгуулах хүсэлт гаргах /Малчдын бүлгийн ахлагч, бусад малчин өрх, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл, оршин суугаа хаяг иргэний үнэмлэхийн хуулбар / малчин өрх бүрийн нэр дээр тоологдсон малын төрөл, тоог заасан жагсаалт; газрын зураг/		
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх		
	-Гэрээ байгуулах		
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх		
	-Гэрээ сунгуулах хүсэлт	116.463 ⁸	
-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах			
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч зун,	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах	25.860	Нийт: 142.323

⁶ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын 3.4.3

⁷ Бусад үйл ажиллагаатай холбоотой бичиг хэргийн зардлыг ийнхүү тооцлоо.

⁸ Засгийн газрын 2009 оны 175 дугаар тогтоолд зааснаар нэг цэгт кадастрын хэмжилт зураглал хийх дундаж үнэ 14577 төгрөг бөгөөд бэлчээрийн газар хэмжээ их учир дунджаар 8 цэг байхаар тооцлоо.

намрын бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх		
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах		
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах		
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх		
	-Гэрээ байгуулах		
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх		
	-Гэрээ сунгуулах хүсэлт		
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах	116.463 ⁹	
Малчин иргэн отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах	25.860	Нийт: 142.323
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх		
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах		
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах		
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх		
	-Гэрээ байгуулах		
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх		
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах	116.463 ¹⁰	

Зарцуулах хугацааны хувьд бэлчээр ашиглагчдын бүлэг **197 цаг 10 минут (11830 минут)**, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч **161 цаг 10 минут (9660 минут)**, малчин иргэн **161 цаг (9670 минут)** гэх байдлаар өөр өөр хугацааг зарцуулахаар байгаа бол гарах мөнгөн зардлын хувьд ялгаагүй **142.323** төгрөг гарахаар байна.

Гурав. Тоон үзүүлэлтийг тооцох

Тоон үзүүлэлт нь хуулийн төсөлд тусгасан үүрэг хичнээн хуулийн этгээдэд, нэг жилд хэдэн удаагийн давтамжтайгаар үүрэг хүлээлгэж байгааг илэрхийлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо тохиолдлыг тоог давтамжийн тоогоор үржүүлнэ. Тоон үзүүлэлтийг тооцохдоо дараах хүчин зүйлийг тооцов. Үүнд:

⁹ Засгийн газрын 2009 оны 175 дугаар тогтоолд зааснаар нэг цэгт кадастрын хэмжилт зураглал хийх дундаж үнэ 14577 төгрөг бөгөөд бэлчээрийн газар хэмжээ их учир дунджаар 8 цэг байхаар тооцлоо.

¹⁰ Засгийн газрын 2009 оны 175 дугаар тогтоолд зааснаар нэг цэгт кадастрын хэмжилт зураглал хийх дундаж үнэ 14577 төгрөг бөгөөд бэлчээрийн газар хэмжээ их учир дунджаар 8 цэг байхаар тооцлоо.

1. Тухайн үүргийг хүлээх иргэний тоо (Тохиолдлын тоо);
2. Тухайн үүргийг жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо (Давтамжийн тоо);

Энэ үе шатанд иргэний гүйцэтгэх үүргийг тухайн харилцаанд оролцогч хичнээн иргэн жилд хэдэн удаа хэрэгжүүлэхийг хуанлийн нэг жилээр тооцож гаргана.

/Хүснэгт 11/

Иргэний гүйцэтгэх стандарт үйлчилгээ буюу үйл ажиллагааны тоон үзүүлэлт

Үүргийн агуулга	Тохиолдлын тоо	Давтамж	Тоон үзүүлэлт
Бэлчээр ашиглагчдын бүлэг улирлын бэлчээрийг гэрээгээр ашиглахтай холбоотой чиг үүргүүд	30.788 ¹¹	4 ¹²	123.152
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч зун, намрын бэлчээрийг гэрээгээр ашиглахтай холбоотой чиг үүргүүд	3545 ¹³	4	14.180
Малчин иргэн отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглахтай холбоотой чиг үүргүүд	30.543 ¹⁴	4	122.172

Тоон үзүүлэлтийн хувьд бэлчээр ашиглагчдын бүлгийн тоон үзүүлэлт **123.152**, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн тоон үзүүлэлт **14.180**, малчин иргэний тоон үзүүлэлт **122.172** тус тус байна.

¹¹ Манай Улсын хувьд бэлчээр ашиглагч бүлгийн тоо тодорхой гаргасан тооцоо судалгаа байхгүй. Практикт бэлчээр ашиглагч бүлэгт 5-15 малчин өрх байна. Өөрөөр хэлбэл, дунджаар 8 өрх юм. Үүнийг Үндэсний статистикийн хорооноос гаргасан 2021 оны нийт малчин өрхийн тоо болох 246.302 -д хуваан үзвэл 30788 малчин өрх болж байна.

¹² Мөн хуулийн төсөлд малчин өрх 4 улиралд өөр өөр бэлчээр ашиглалтын бүлэгт багтах боломжтой учраас давтагдах үзүүлэлтийг 4 удаа байна гэж үзлээ.

¹³ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас гаргасан статистикийн дагуу эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн тоо 2021 оны байдлаар 3545 байна.

¹⁴ Хуулийн төсөлд тусгаснаар Монгол Улсын нийт бэлчээрийн 10 хүртэл хувь нь отрын нөөц бэлчээр байх тул нийт 305430 малчин иргэний 10 хувийг тооцсон болно.

Дөрөв. Зардлын дүнг тооцох

Энэ хэсэгт өмнөх шатанд тооцож гаргасан стандарт үйл ажиллагаа тус бүрийг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлын тооцоо болон тоон үзүүлэлтийг хооронд нь үржүүлж нийт захиргааны зардлын дүнг гаргана.

/Хүснэгт 12/

Иргэний гүйцэтгэх стандарт үйлчилгээ буюу үйл ажиллагаанд зарцуулах нийт мөнгөн зардал

Үүргийн агуулга	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Мөнгөн зардал /төгрөг/	Тоон үзүүлэлт	Нийт зардал
Бэлчээр ашиглагчдын бүлэг улирлын бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Бүлэг байгуулахаар санаачлан хоорондоо зөвшилцөх	142.323	123.152	17.527.362.096
	-Зөвшилцөлд хүрсэн малчин өрхүүд бүлэг үүсгэн байгуулах хурал хийж, үүсгэн байгуулсан баримт бичгээ баталгаажуулах			
	-Бүлгийн ахлагчаа сонгож хамтран ажиллах гэрээ, дүрмээ батлах			
	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах			
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх			
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах			
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах болон малчдын бүлэг байгуулах хүсэлт гаргах /Малчдын бүлгийн ахлагч, бусад малчин өрх, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн талаарх мэдээлэл, оршин суугаа хаяг иргэний үнэмлэхийн хуулбар / малчин өрх бүрийн нэр дээр тоологдсон малын төрөл, тоог заасан жагсаалт; газрын зураг/			
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх			
	-Гэрээ байгуулах			
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх			
	-Гэрээ сунгуулах хүсэлт			

	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах			
Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч зун, намрын бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах	142.323	14.180	2.018.140.140
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх			
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах			
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах			
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх			
	-Гэрээ байгуулах			
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх			
	-Гэрээ сунгуулах хүсэлт			
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах			
Малчин иргэн отрын нөөц бэлчээрийг гэрээгээр ашиглах	-Гэрээгээр ашиглах бэлчээрийг тоймлон гар зураг гаргаж, ашиглах хуваарь хийж баталгаажуулах	142.323	122.172	17.387.885.556
	-Бэлчээрийн хил заагийг тогтоон зөвшилцөх хөршөө тодорхойлж, тэдгээртэй хэлцэл хийх			
	-Хэлэлцэн зөвшилцсөн хил заагийн талаар тэмдэглэл үйлдэж баталгаажуулах			
	-Сумын Засаг даргад бэлчээр ашиглах хүсэлт гаргах			
	-Сум, дүүргийн Засаг даргаас шийдвэр гаргаж гэрээ байгуулахаар шийдвэрлэх			
	-Гэрээ байгуулах			
	-Бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын үзүүлэлт, даацын хэмжээг тогтоож ашиглуулах бэлчээрийг хүлээлгэн өгөх			
	-Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах			

Эндээс харахад 1 жилийн хугацаанд бэлчээр ашиглагчдын бүлэг бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах гэрээ байгуулахад нийтдээ **17.527.362.096** төгрөгийн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах гэрээ байгуулахад нийтдээ **2.018.140.140** төгрөгийн, малчин иргэн бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах

гэрээ байгуулахад нийтдээ **17.387.885.556** төгрөгийн зардлыг тус тус зарцуулахаар байна.

Тав. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах

Энэ хэсэгт тодорхой шалгах асуултын дагуу зардлыг нь тооцсон үүрэг нэг бүрийн зардлыг бууруулах, аж ахуйн салбарт үүсгэх дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгалаа.

Гэрээгээр ашиглахаар хүсэж буй бэлчээрийн газрын зураг гаргуулах зардлын хувьд бэлчээр ашиглагчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, малчин иргэнд хөнгөлөлт үзүүлэхээр Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль болон бусад хууль тогтоомжид тусгасан тохиолдолд энэхүү зардал хэмнэгдэхээр байна. Өөрөөр хэлбэл бэлчээр ашиглагч буюу бэлчээр ашиглагчдын бүлэг, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч, малчин иргэний бэлчээрийн зураг гаргуулах дундаж зардал болох 116.463 төгрөгөөс тодорхой хувь, хэмжээгээр хөнгөлсөн тохиолдолд энэхүү зардал буурна.

Бусад үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын хувьд тухай бүр нь хэмнэх боломжтой зардал бий болохоор байна. Тухайлбал, гэрээ байгуулах, гар зураг гаргах гэх мэт үйл ажиллагаанд гарах бичиг хэргийн зардлыг хэмнэх боломжтой юм.

Тохиолдлын тоо болон давтамжийн тухайд хамгийн өндөр үзүүлэлтээр сонгож авсан. Тиймээс тухайн тохиолдол болон давтамжийн тоо буурах бүрэн боломжтой. Тухайлбал, бэлчээр ашиглагчдын бүлгийн тоо, 4 улиралд өөр өөр бэлчээр ашиглагчдын бүлэгт орох боломжтой давтамжийн тоо, малчин иргэний тоо зэрэг нь буурах боломжтой хэмээн ойлгож болно.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү хуулийн төслийн зардлын тооцооны судалгаагаар хууль тогтоомжийн зохицуулалтын улмаас иргэн, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан тооцоолов.

Судалгааны хүрээнд Газрын тухай тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгжилттэй холбогдон гарах иргэн, төрийн байгууллагаас гарах зардлыг нэмэлт, өөрчлөлт орсон зүйл заалт тус бүрээр тоохон боловсруулсан болно.

Хуулийн төсөлд Газрын тухай хуульд хэд хэдэн зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгажээ. Улмаар хуулийн төслийн хэрэгжилтийн хүрээнд иргэн, төрийн байгууллагаас гарах зардлын тооцоог дараах байдлаар дүгнэж болохоор байна.

Нэгдүгээрт, Төрийн байгууллагаас гарах зардал:

Боловсруулсан хуулийн төслийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн байгууллагаас 85,006,7382 төгрөгийн зардал гарахаар байна. Үүнд газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд дурдсан сумын газрын даамлын бэлчээрийн гэрээг мэдээллийн санд бүртгэх чиг үүргийг хэрэгжүүлэх хүний нөөцийн зардал хамаарна.

Хоёрдугаарт, Иргэнд үүсэх зардал:

Бэлчээрийг гэрээгээр ашиглуулахад зарцуулах хугацааны хувьд бэлчээр ашиглагчдын бүлэг 197 цаг 10 минут (11830 минут), эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 161 цаг 10 минут (9660 минут), малчин иргэн 161 цаг (9670 минут) гэх байдлаар өөр өөр хугацааг зарцуулахаар байна. Харин тоон давтамж бүрт гарах мөнгөн зардлын хувьд 142.323 төгрөг нэг бэлчээр ашиглагч субъектээс гарахаар байна.

Тоон үзүүлэлтийн хувьд бэлчээр ашиглагчдын бүлгийн тоон үзүүлэлт 123.152, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчийн тоон үзүүлэлт 14.180, малчин иргэний тоон үзүүлэлт 122.172 тус тус байна.

Нэгтгэн дүгнэвэл 1 жилийн хугацаанд нийт бэлчээр ашиглагчдын бүлэг бэлчээрийн газрыг гэрээгээр ашиглах гэрээ байгуулахад 17.527.362.096 төгрөгийн, нийт эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч бэлчээрийн газрыг ашиглах гэрээ байгуулахад 2.018.140.140 төгрөгийн, нийт малчин иргэн бэлчээрийн газрыг ашиглах гэрээ байгуулахад 17.387.885.556 төгрөгийн зардлыг тус тус зарцуулахаар байна¹⁵.

¹⁵ Энэхүү нийт зардлыг тооцоолохдоо нэг бэлчээр ашиглагчаас гарах мөнгөн зардлыг тоон үзүүлэлт буюу тохиолдлын тоо болон давтамжийн тоогоор үржүүлж гаргасан.